



ДУНДГОВЬ АЙМАГ
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/24

Цагаан-Овоо

Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон
шалгуруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтын журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Суварга, Наран, Буянт багуудын нутаг дэвсгэрт байршилтай 144848.22 га газарт салхин сэнсний цахилгаан станцын зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах газрын төсөл сонгон шалгаруулалтыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дотор газрын биржийн цахим системээр зохион байгуулсугай.


2. Төсөл сонгон шалгаруулалт хүлээн авах материалд тавигдах шаардлага, үндсэн шалгуурыг хавсралт ёсоор баталсугай.

3. Төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Э.Энхжаргал), Газрын даамал (Г.Ууган-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ



**ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ТӨСӨЛ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА
ҮНДСЭН ШАЛГУУР**

Ерөнхий мэдээлэл:

Луус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 56 тогтоолоор батлагдсан “Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний 3056615, 3056616, 3056617, 3056618, 3056619, 3056620, 3056621, 3056622 төлөвлөлтийн нэгж талбар.

Байршил: Луус сумын Суварга, Наран, Буянт

Зориулалт: Салхин сэнсний цахилгаан станц

Хэмжээ: 144848.2268 га

Эрхийн төрөл: Эзэмших, ашиглах

Төсөл сонгон шалгаруулалтад оролцох үндсэн шалгуур:

Төсөл нь газар эзэмшүүлж, ашиглуулахад тавигдах шаардлага, ажил үйлчилгээний чиглэлд нийцсэн, “Төслийн удирдлага арга зүйн заавар” MNS ISO21500:2017 стандартын дагуу боловсруулсан байна.

Хэл: Монгол хэлээр (Гадаадын хуулийн этгээд бол эх хувь монгол хэлээр гадаад хэл дээрх хувийг дагалдуулж болно)

Төсөл ирүүлэгчийн бүрдүүлэх материал:

- Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхний хуулбар
- Хамтарч ажиллах хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ
- Төслийн баримт бичиг
- Бүтээн байгуулалтын ажлын товч танилцуулга, шинээр бий болох ажлын байрны тоо хэмжээ, улс орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ, байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх бол технологийн танилцуулга, бүтээн байгуулалтын ажлын үе шатны төлөвлөгөө

- Салхин сэнсний цахилгаан станц байгуулах ажлын техник эдийн засгийн үндэслэл
- Хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо

Төсөл хүлээн авахад тавигдах шаардлага:

Төслийг газрын цахим биржийн систем www.mle.mn –ээр зарлаж, зохион байгуулах бөгөөд төсөл сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ дээрх цахим системээр хугацаанд нь ирүүлсэн төслийн материалыг үнэлнэ.

Төсөл сонгон шалгаруулалтын дүнд нийтэд зарласан өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан ялагчтай гэрээ байгуулна.

Холбогдох мэдээллийг www.mle.mn цахим хуудас, тодруулга, лавлагааг сумын Газрын даамлын 80028332 утсаар холбогдож авна уу.